



## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ**

**ДЭМБ-аас гаргасан “Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцоо, түлхүүр 78 үзүүлэлт”-ийг гаргахад шаардлагатай мэдээллийн бэлэн байдлыг өөрийн орны нөхцөлд харьцуулан судалсан дүн шинжилгээний тайлан**

**Хөгжлийн төлөвлөлт хамтын ажиллагааны алба**

**Улаанбаатар 2020**

## Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцоо

### Нэг. Товч агуулга

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцоо гэдэг нь Бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээ (УНС), Тогтвортой хөгжлийн зорилт (SDGs) болон эрүүл мэндтэй холбоотой бусад зорилт, стратегийг биелүүлэхэд чиглэсэн олон тооны үзүүлэлтүүдийг хянах замаар эрүүл мэндийн ажиллах хүчний талаарх мэдээлэл, хүртээмж, хэрэглээг сайжруулдаг систем юм.

2016 оны 5-р сард Дэлхийн Эрүүл Мэндийн 69-р Ассемблейд хүний нөөцийн талаархи дэлхийн стратеги: Ажилчдын хүч 2030 батлагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Ассемблейн 69.19-р тогтоолоор “Бүх гишүүн орнуудыг НҮБ-ын эрүүл мэндийн ажилтнуудын бүртгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэхийг НҮБ-д үүрэг болгов” гэж тунхагласан байна. Эрүүл мэндийн салбарын хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийн дээд түвшний комисс, НҮБ-ын Ерөнхий ассемблейгийн 2016 оны 12-р сард баталсан тогтоол (A/RES/71/159) хоёулаа эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцооны хэрэгжилтийг дэмжсэн байна.

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцооны (ЭМСАХ) зорилго нь эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийн системийн харилцан үйлчлэлийг стандартчилах, түүнчлэн хүн амын эрүүл мэндийн талаархи бодлогын үр дүнгээр бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээний хүрэх түвшинд очиход дэмжлэг үзүүлэхэд оршино.

ЭМСАХ-ний гарын авлага нь арав орчим модулиудаас бүрдсэн 78 үндсэн шалгуур үзүүлэлтийг агуулсан байдаг бөгөөд эдгээр нь тухайн орны эрүүл мэндийн ажилтнуудын байдал, чиг хандлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилготой юм.

Эдгээр үзүүлэлтүүд нь эрүүл мэндийн ажилтнуудын тэргүүлэх чиглэлийг хамарсан бөгөөд улс орон, бүс нутгийн болон дэлхийн тайланд хамааралтай мэдээлэл болдог. Энэхүү тооцоолж гаргах боломжтой үзүүлэлтүүд нь юуны түрүүнд Бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээний эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоонд суурилдаг байна.

### **1.1. Бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээ, Тогтвортой Хөгжлийн зорилт: улс орнуудад тулгардаг нийтлэг бэрхшээл**

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний (ЭМСАХ) тоо хэмжээ, ур чадвараас гадна салбарын багш, сургагч багш нар нь хүн амын эрүүл мэндийн аливаа зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээ (БНЭМХХ) (ДЭМБ 2017) ба эрүүл мэндэд чиглэсэн НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ын хүрэх түвшинд дээрх асуудал багтдаг. Гэсэн хэдий ч дэлхийн улс орнуудад эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний боловсрол, сургалт, ажлын байранд байршуулах, ажиллуулах, тогтоон барих зэрэг олон талт тулгамдсан асуудлууд байсаар байна (ДЭМБ 2016).

Эрүүл мэндийн ажилчдыг ажлын байраар хангах нь улс орны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар, гүйцэтгэлд шууд нөлөөлдөг гол бэрхшээлүүдийн нэг юм (Макпэйк 2014 он). Иймд ДЭМБ болон хамтран ажиллагч байгууллагууд эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн талаарх олон улсын стратеги

(ЭМСХНТОУС) боловсруулсан. Ажилчдын хүч 2030 (ЭМСХНТОУС) нь БНЭМХХ болон ТХЗ-ын зорилтыг биелүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн ажилтны буюу ажиллах хүчний бодлогын хөтөлбөрийг боловсруулсан болно (ДЭМБ 2016с).

## **1.2. Эрүүл мэндийн салбар дах хүний нөөцийн талаарх олон улсын стратеги**

Эрүүл мэндийн салбар дах хүний нөөцийн талаарх олон улсын стратеги: Ажилчдын хүч 2030 нь 2016 оны 5 сард болсон 69 дэх удаагийн Дэлхийн Эрүүл мэндийн Чуулганы тогтоолоор батлагдсан. Энэхүү стратеги дэхь 19 зорилго нь эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд хамаарах эрүүл мэндийн нийт ажилтнуудын хүртээмж, хамрах хүрээ, чанарыг хангахад чиглэгддэг.

Энэхүү үйл ажиллагаа нь хангалттай хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд үндэсний, бүс нутгийн, дэлхийн түвшинд үр дүнтэй бодлогыг хэрэгжүүлснээр үр дүнд хүрнэ гэж үзсэн. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд ЭМСХНТОУС нь эрүүл мэндийн салбарын ажиллах хүч (ЭМСАХ) -ний дата буюу өгөгдөл, нотолгоо, мэдээ мэдээллийг бэхжүүлэх зэрэг олон зорилтуудыг дэвшүүлсэн. 2020, 2030 он гэхэд бүх улс орнууд эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний (ЭМСАХ) бүртгэл, эрүүл мэндийн ажилтнуудын нөөц, боловсрол, хуваарилалт, урсгал, эрэлт, чадавхи, урамшуулалт цалин хөлс, нөхөн олговрын чиглэлээр мэдээлэл цуглуулж ахиц дэвшил гаргасан байна гэж таамагласан.

Аль нэг улсад хэрэгжүүлэхдээ ЭМСАХ-ын мэдээлэл, хүртээмж, бүрэн байдал, чанарт тулгуурлаж хариуцлагатайгаар өөрчлөлт хийнэ. Тодруулбал, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний чадавхи, динамикийг хянахын тулд бүртгэл нь чухал бөгөөд ингэснээр улс орнуудын хоорондох эрүүл мэндийн ажилтнуудын тоо баримт, үзүүлэлт, бүртгэл, мэдээллийг солилцох боломж бүрдэнэ гэж үзсэн.

Гишүүн орнууд эрүүл мэндийн ажилтнуудын найдвартай, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх эрүүл мэндийн ажилтнуудын үндэсний мэдээллийн системийг яаралтай бэхжүүлэх шаардлагатай байна. Эдгээр мэдээлэл нь эрүүл мэндийн ажилтнуудын бодлогын зохистой байдал, үр нөлөөг үнэлэхэд тусалдаг бөгөөд үүнийг үр дүнтэй хэрэгжүүлвэл эрүүл мэндийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулан хөрвүүлэх боломжтой юм гэж үзсэн.

Дата буюу өгөгдөл, шалгуур үзүүлэлт, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тооцоо, хөдөлмөрийн зах зээлд дүн шинжилгээ хийхэд ашиглах дата түүний багтаамж зэрэг нь бүх улс орны хувьд тулгамдсан асуудал болж байгаа юм. Нотолгоо, тооцоо, үйл ажиллагааг бэхжүүлэн сайжруулах замаар уялдаа холбоотой нарийвчилсан аргачлалыг ашиглаж эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлд нягт нямбай судалгаа, шинжилгээ хийх хэрэгтэй. Энэ нь тухайн улс хэмжигдэхүүн, арга аргачлалаа зохицуулахад өндөр ач холбогдолтой юм.

## **Хоёр. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцооны ач холбогдол**

### **2.1. Олон улсын түвшин дэх ач холбогдол**

ЭМСАХТ-ний зорилго нь эрүүл мэндийн салбарын ажиллагсдын мэдээллийн системийг харилцан үйлчлэлээр стандартчилах, өөрөөр хэлбэл эрүүл мэндийн ажиллах хүчний талаарх мэдээллийг үндэсний эрүүл мэндийн систем, түүнчлэн олон улсын

мэдээллийн системд солилцох боломжийг бүрдүүлэх явдал юм. Ийм байдлаар шийдвэр гаргахад шаардлагатай эрүүл мэндийн ажилтнуудын мэдээний санг нэгтгэх, харуулах боломжтой бөгөөд ЭМСАХТ нь улс орнуудад үндэсний хэмжээнд эрүүл мэндийн ажилтнуудын талаарх нотолгоонд суурилсан мэдээлэл болж бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт чиглүүлэгч, дэмжлэг үзүүлэх хэрэгсэл болж чадна гэж үзсэн байна. ЭМСАХТ нь хөдөлмөрийн зах зээлийн тооцоог гаргах, тусгайлсан бодлогын загвар боловсруулах, бодлогын өөрчлөлтийн нөлөөг шалгах зэрэгт ашиглагдана гэж зарим судлаачид үзжээ. (Мк Пэйк 2014, Скотт 2016). Мөн түүнчлэн ЭМСАХТ нь БНЭМХ болон ТХЗ, ЭМСХНТОУС-д хүрэх хүчин чармайлтыг хянаж, дэмжиж чадна. ЭМСАХТ нь үүнийг дараах байдлаар хийх болно.

- эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийг жил бүр, цаг тухайд нь цуглуулах нэгдсэн арга хэлбэрийг бий болгох
- мэдээллийн архитектур, харилцан үйлчлэлийг сайжруулах,
- ажиллах хүчний стратеги төлөвлөлт ба олон улсын түвшинд хяналт шалгалтыг дэмжих үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох замаар.

## **2.2. Үндэсний түвшин дэх ач холбогдол**

ЭМСАХТ-ны шалгуур үзүүлэлтүүдийг бодлогын тодорхой хамааралтайгаар сонгосон бөгөөд үүнийг аливаа улс өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ашиглах, өөрчлөх боломжтой. ЭМСАХТ нь бодлогын дүн шинжилгээ хийх, уялдаатай хүрээг бий болгох зорилготой боловч ЭМСАХТ-г уян хатан, модуль байдлаар ашиглаж болно.

ЭМСАХТ-ний шалгуур үзүүлэлтийг багтаасан 10 модуль нь бүрэлдэхүүн хэсэг, бодлогын хүрээг бүхэлд нь хамарсан хэдий ч тухайн улсын онцлогт зориулсан шалгуур үзүүлэлтийг багтаах боломжтой гэдгийг тэмдэглэн хэлэх нь чухал.

Улс бүрийн боловсролын систем, эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, эрүүл мэндийн үйлчилгээ өөр өөр байдаг, тухайн бүрэлдэхүүн хэсгийг шаардлагын дагуу бодлогын хүрээнд сайжруулан өөрчлөх боломжтой. Тиймээс улс орнууд ЭМСАХТ-ны модулийг өөрсдийн орны хэрэгцээ, зорилгодоо нийцүүлэн сонгох, эрэмбэ тогтоох боломжтой, ингэснээр эцэст нь ЭМСАХТ-ны бүрэн хамрагдалт, сонголтыг хийх боломжтой болно. ЭМСАХТ нь дэвшилтэт шинж чанартай тул улс орнуудад үзүүлэх үр өгөөжийн зарим нь нэн даруй, бусад нь урт хугацаанд ашиглагдах боломжтой болно.

Олон улсын болон үндэсний түвшинд олон үзүүлэлт байх тусам эрүүл мэндийн ажиллах хүчний ерөнхий тойм зураглалд илүү нарийвчлалтай дүн шинжилгээ хийх, үр дүнтэй бодлого боловсруулах, БНЭМХХ-д хүрэх ахиц дэвшил гаргах боломжтой болно. ЭМСАХТ-ны системийг үндэсний хэмжээнд бүрэн боловсруулж, хэрэгжүүлсний дараа ЭМСАХТ-г ашиглахын гол давуу талууд нь дараахь байдалтай байна. Үүнд

- Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тоо хэмжээ, шинж чанар, тархалтын талаар илүү сайн ойлголттой болох; үүнээс үзэхэд улс орнууд эрүүл мэндийн ажилтнуудаа бэхжүүлэх, цаашлаад хэрэгцээ, шаардлагын талаархи ойлголтыг бий болгож чадна.

- Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний талаарх чанарын өндөр шаардлага хангасан мэдээлэлтэй болж тухайн улсын хэрэгцээ шаардлагад нийцсэн нотолгоонд тулгуурласан бодлогын шийдвэр гаргах үндэслэл болно
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдалт, дагалдаж гарч ирэх үр дагавар ялангуяа эрүүл мэндийн системийн онцлог шинж чанарыг бий болгон сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ
- БНЭМХХ-д дэмжлэг үзүүлэх эрүүл мэндийн салбарын ажиллагсдын боловсрол, сургалтын талаарх өөрчлөлт, цар хүрээг удирдан чиглүүлэх мэдээллэх чадамжтай болно.
- Боловсрол, эрүүл мэнд, сангийн яам зэрэг холбогдох яамдын хоорондын бодлогын харилцан уулзалт, хэлэлцээрээр дамжуулан бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсронгуй болгох.
- ЭМСАХТ-ний бүх модулиудад хэмнэсэн хөрөнгө оруулалтыг багтаасан ба энэ нь датад суурилсан төлөвлөгөө, бодлогын эрэлт хэрэгцээ, чадавхийг бэхжүүлэхэд түлхэц болно.
- Эрүүл мэндийн ажиллах хүчний чиг хандлагыг олж илрүүлэх, хянах сайжруулах, эрүүл мэндийн тогтолцооны хөгжил, уян хатан төлөвлөлтийн талаар системчилсэн судалгаа хийх боломж бүрдэнэ

### **2.3. Бүс нутгийн түвшин дэх ач холбогдол**

Үндэсний хэмжээнд үзүүлэх үр өгөөжөөс гадна ЭМСАХТ нь бүс нутгийн түвшинд болон дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн ажиллах хүчний зураглалыг харьцуулахад хялбар болно. Улс орны тайлагналт ба олон улсын харьцуулалтаар дамжуулан ЭМСАХТ нь улс хоорондын чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл, мэдлэг солилцох, түүнчлэн эрүүл мэндийн ажилтнуудын цаашдын чиг хандлагын талаар илүү боловсронгуй судалгаа хийх боломжийг олгодог.

**Гурав. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцоо: үзэл баримтлал ба тойм**

#### **3.1. Үндэслэл, ерөнхий бүтэц**

Энэхүү тогтолцоо нь боловсрол, эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн динамик байдлыг харуулсан бөгөөд үүний үр дүнд эдийн засаг, хүн ам, нийгэм нь БНЭМХХ, эрүүл мэндийн оновчтой үйлчилгээг олж авахад хүргэдэг гэж үзэж байна. Энэ утгаараа эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоо нь ЭМСХНТОУС-ийн үе шатууд, БНЭМХХ, ТХЗ-ууд зэрэгт хүрэхэд хувь нэмрээ оруулж болох, эрүүл мэндийн ажиллах хүчний талаар бодлогын түвшинд улс орнуудад тодорхой чиглэлүүдийг санал болгоход дэмжлэг болдог.


Хүрээ буюу бүтцийн доод түвшинд эрүүл мэндийн ажилтнуудын тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд шаардлагатай хүртээмжтэй байдлыг хангах дөрвөн бодлогын бүлгийг багтаасан болно:

1. Үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого
2. Орох, гарах урсгалыг шийдвэрлэх бодлого
3. Буруу хуваарилалт, үр ашиггүй байдлыг шийдвэрлэх бодлого
4. Хувийн хэвшлийг зохицуулах бодлого

Эхний гурван бодлого нь боловсролын салбарын өөр өөр хэсгүүд, эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн динамиктай холбоотой бөгөөд системд "оролт – хөдөлмөрийн бүтээмж - гаралт" дарааллаар харилцан хамааралтай байдаг.

Хувийн хэвшлийг зохицуулах бодлого нь эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн бүрэн хүрээг хамардаг.

**Зураг1: Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий бүдүүвч**



### 3.2. Модуль аргачлал

ЭМСАХТ нь БНЭМХХ болон ТХЗ-д хүрэхээр чиглэсэн үндэсний түвшний эрүүл мэндийн ажиллах хүчний бодлогыг дэмжих зорилготой 10 үндсэн модуль, 78 үндсэн үзүүлэлтүүдийг агуулдаг. 10 модулийн үзүүлэлтүүд нь хөдөлмөрийн зах зээлийн гурван чухал бүрэлдэхүүн хэсэг болох боловсролын бүрэлдэхүүн хэсэг, ажиллах хүчний бүрэлдэхүүн хэсэг, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдэд багтдаг (Зураг 2).

**Зураг 2: ЭМАХҮТ-ны модулиудын дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн зах зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан нь**

Зураг 2: ЭМАХҮТ-ны модулиудын дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн зах зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан нь



10 модуль тус бүрийн зорилго, агуулгыг доор дэлгэрэнгүйгээр тайлбарлав. Модуль 1 бол эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хамгийн чухал мэдээллийг цуглуулсан ЭМСАХТ-ны эхлэх гол цэг юм.

### 3.2.1. Модуль 1: Эрүүл мэндийн салбарын (идэвхитэй) ажиллах хүчний нөөц

Энэхүү модуль нь ЭМСАХ-ний бүтэц, тархалтын талаархи дэлгэрэнгүй ойлголтыг өгдөг. Шалгуур үзүүлэлтүүдийг газарзүйн хуваарилалт, нас, хүйс, институцийн салбар, байгууламжийн төрлөөр нь ялган цуглуулдаг. Бодлогын хамаарлын хувьд энэхүү модуль нь одоогийн ажиллах хүч нь БНЭМХХ-ний хэмжээнд үйлчилгээ үзүүлэхэд хангалттай эсэхийг судлахад тусалдаг. Энэ нь тодорхой мэргэжил, чадварын зөрүүг, газарзүйн болон салбарын хуваарилалтын зөрүүг илрүүлэх боломжийг олгодог. ЭМСАХ-ийн бүрэлдэхүүн, тархалтыг ойлгох нь ЭМСАХ-ний боловсрол, нөөцийг хадгалах, дахин хуваарилах талаархи бодлогын оролцоог төлөвлөх, хэрэгжүүлэх боломжийг олгодог. Модуль 1 нь эрүүл мэндийн ажилтнуудын хуваарилалтын талаар тусдаа үзүүлэлтүүдийг агуулдаг бөгөөд энэ нь эрүүл мэндийн ажилтны хүртээмжийн тэгш бус байдлыг багасгах явцыг хянах боломжийг олгодог. Гадаад улсад суралцсан болон гадаадаас гаралтай эрүүл мэндийн ажилтнуудын эзлэх хувийг харуулсан үзүүлэлтүүд нь ЭМСХНТОУС-тай холбоотой.

Зураг 2-ийн зүүн баганад харуулсны дагуу боловсролын бүрэлдэхүүн хэсгийн бодлогыг дэмжих гурван модулийг байршуулсан бөгөөд энэ нь эрүүл мэндийн ажиллах хүчин ба ЭМСАХТ-ний суурь ба орц болж буй юм.

### 3.2.2. Модуль 2, 3 ба 4: Боловсрол

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тоо хэмжээ, чанар, хамаарлыг нэмэгдүүлэхийн тулд боловсрол, сургалтын тогтвортой өсөлт, шинэчлэлтийг дэмжих зорилгоор эдгээр модулиудыг боловсруулсан бөгөөд ингэснээр үндэсний эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулж болно. Модулиудын мэдээлэл нь

эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үйлчилгээ, хүн төвтэй, олон нийтэд суурилсан үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн ажилтны чиглүүлэх удирдамж болж мэдээллээр хангах болно. Энэхүү ЭМСАХ нь эрүүл мэнд болон нийгмийн салбарын бүх төрлийн ажилчдыг багтаасан болно.

### **3.2.3. Модуль 2: Боловсрол ба сургалтын үйл ажиллагаа**

Энэхүү модуль нь эрүүл мэндийн салбарт ажилтнуудын боловсрол, сургалтыг хариуцсан байгууллагуудын жагсаалт, хөтөлбөр, өргөдөл, элсэлт, гарах / завсардалт, төгсөлтийн талаарх мэдээллийг багтаасан чанар, хүчин чадлын талаарх мэдээллийг өгдөг. Шалгуур үзүүлэлтийг ТХЗ 4 (Боловсрол), салбар хоорондын уялдаа холбоог дэмждэг шалгуур үзүүлэлтүүд, тухайлбал жендэрийн тэгш байдлыг хангахтай уялдуулж гаргасан байна. Энэхүү модуль нь оюутны сонгон шалгаруулалт, элсэлт, бүртгэл болон багшлах мэргэжилтнүүдийн бодлогыг төлөвлөх, хянах боломжийг олгодог.

### **3.2.4. Модуль 3: Боловсрол ба сургалтын журам, магадлан итгэмжлэл**

Энэхүү модуль нь ЭМСАХ-ний салбар хоорондын асуудлыг зохицуулах механизмыг дэмждэг. Боловсролын журамд үндэслэсэн үзүүлэлтүүд нь чанарын баталгаа, боловсрол, сургалтын шаардлагын талаархи мэдээллийг өгдөг. Магадлан итгэмжлэлийн механизм, тэдгээрийн стандарт нь маш чухал ач холбогдолтой тул эрүүл мэндийн ажилтнуудын боловсролын талаарх үндэсний төлөвлөгөөг гаргахдаа эрүүл мэндийн ажилтнууд нь хүн амын хэрэгцээнд нийцсэн ур чадвартай байх ёстой гэж үзэж үндэсний эрүүл мэндийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан байх ёстой. Тусламж үйлчилгээ үзүүлж буй ажиллагсдын сургалтын үзүүлэлт нь эрүүл мэндийн салбарын сургалтыг бусад боловсролын салбарын бодлого, хөтөлбөр буюу техник, мэргэжлийн сургалтыг багтаасан насан туршийн боловсрол олгохоор бүтэцтэй нийцүүлэх хандлагатай харагдаж байгаа юм. Эдгээр үзүүлэлтүүд нь ЭМСАХ-ний боловсрол, сургалтын чанар, хамаарлыг сайжруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсрол, сургалтын зохицуулалт, менежментэд оролцох чиглэлийг тодорхойлох боломжтой юм.

### **3.2.5. Модуль 4: Боловсролын санхүүжилт**

Энэхүү модуль нь эрүүл мэнд, боловсролын салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэн, насан туршийн боловсролын тогтолцоонд хөрөнгө оруулалт хийх үр дүнтэй санхүүжилтийн архитектурыг дэмжихийг зорьсон. Эдгээр дата-г ажлын байранд авч үлдэх бодлогыг дэмжих, боловсролын тэгш хүртээмжийг хангах, насан туршдаа суралцах боломжийг дэмжих зорилтот хөрөнгө оруулалтын талаархи ойлголтыг сайжруулах, хувьсан өөрчлөгдөх боловсрол, ур чадвар, ажлын байр бий болгоход хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай төсвийн нөөцийг олж тогтоох, ашиглахад ашиглаж болно.

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний урсгал, гадагшлах асуудлыг шийдвэрлэх бодлогыг модуль 1-ээс гадна дараахь гурван ажиллах хүчний модулаар хянах боломжтой.

### **3.2.6. Модуль 5: Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн урсгал**

Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх, гарах үйл ажиллагааг Модуль 5-т хэмждэг. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх үзүүлэлтүүд нь дотоодын эрүүл мэндийн ажилтнуудын нөөцийг гадаадын эрүүл мэндийн ажилчдаас ялгаж, сайн дурын болон сайн дурын бус ажилчдыг гарч буйд хамтад нь хяналт тавьдаг. Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн баланс буюу тэнцвэртэй байдлын талаарх мэдээллийг сул орон тоо, ажилгүйдлийг хянах замаар



цуглуулж, боломжтой бол дэд үндэсний түвшинд салгаж авч үзнэ. Ажиллах хүчний урсгалын хэмжээ болон хөдөлгөгч хүчний талаар илүү сайн ойлголттой болвол ажилд авах, хадгалах бодлогыг үр дүнтэй болгох үндэс суурь болж өгдөг.

### **3.2.7. Модуль 6: Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл**

Энэхүү модуль нь хөдөлмөр эрхлэлтийн шинж чанар, ажлын нөхцлийг авч үздэг. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд дүн шинжилгээ хийж үүсч буй шалтгааныг тайлбарлах, хэрэгжүүлэх явцыг ахиулж, хянах ажлыг хөнгөвчлөх боломжтой. Эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрийн цаг, хөдөлмөрийн зах зээлийн онцлогоос хамаарч хуваарилалт нь ЭМСАХ-ний динамикийг ойлгоход чухал ач холбогдолтой байдаг. Олон улсын хөдөлмөрийн стандартад тусгагдсан ажлын цаг ба хөдөлмөрийн тэнцвэрт байдал гэх мэт чухал зүйлс дээр хуваарилалт нь үндэслэдэг. Хөдөлмөрийн нөхцлийн шалгуур үзүүлэлтүүд нь ТХЗ 6-д дэмжигдсэнээр бүх хүнд ажилд ахиц гаргахад нөлөөлөх хүчин зүйл буюу орц болж чадна.

### **3.2.8. Модуль 7: Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний зардал, цалин хөлс**

Энэ модульд эрүүл мэндийн салбарын ажиллах хүч, цалин хөлсний зардлыг харуулсан болно. Гэвч хувийн хэвшлийн салбарын орлогод зайлшгүй хяналт тавих хэрэгтэй. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн талаархи дата нь ТХЗ 6-д заагдсан ажлуудыг гүйцэтгэхэд хувь нэмэр болж, ТХЗ 5-д тусгагдсан жендэрийн тэгш байдлыг хангах асуудалд чухал хувь нэмэр оруулж чадна. Түүгээр ч үл барам эдийн засгийн дүн шинжилгээ нь засгийн газар (жишээ нь Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам), мөн хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй төсөв хэлэлцээ хийхэд чухал ач холбогдолтой юм.

Зураг 2-ын баруун баганад дор дурдсан гурван модулийн тусламжтайгаар хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийлүүлэлт ЭМСАХ-ний үр дүнгийн хэмжүүрийг шийдвэрлэх бодлогыг тусгасан болно.

### **3.2.9. Модуль 8: Эрүүл мэндийн ажиллагчдын ур чадвар**

БНЭМХХ-д хүрэхийн тулд янз бүрийн нөхцөлд чадварлаг эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллуулах зайлшгүй шаардлагатай байдаг. Модуль 8 нь эрүүл мэндийн ажилтнуудын ур чадварын холимог бүрэлдэхүүний үзүүлэлтүүдийг агуулдаг. Энэ нь бусад модулийн үзүүлэлтүүд дээр үндэслэн ажиллах хүчний бүтцийг салбар, мэргэжлийн бүлгээр задалдаг. Ингэснээр хөдөлмөр хангамжийн хэлбэр нь улс орнуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүн амын бүтэцэд хэрхэн нийцэж байгаа талаарх ойлголтыг өгдөг. Ур чадварын хослол /skill mix/, тохиолдол хослол /case mix/ нь ялангуяа эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн өвчтөн төвтэй тусламжийг сайжруулах, нэгтгэх ажилд чухал ач холбогдолтой юм. Анхан шатны тусламж үйлчилгээнд ур чадвартай мэргэжилтнээр тусламж үзүүлэх тал дээр илүү анхаарч үздэг. Энэхүү модульд нэмэлтээр бодлогын хоёр үзүүлэлт, жишээ нь эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах боломжийг Олон улсын эрүүл мэндийн журмаар (ДЭМБ 2005а) хэрэгжүүлэх боломжтой ба тархвар судлалын сургалтын хөтөлбөрийн талаар нэмэлт мэдээллийг өгдөг.

### **3.2.10. Модуль 9. Засаглал болон эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний талаарх бодлогууд**

Энэхүү модуль нь засаглал болон эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний талаарх бодлогыг багтаадаг. Засгийн газрын шалгуур үзүүлэлтүүдэд тухайн улс ЭМАХ-ний салбар

хоорондын хөтөлбөрийг зохицуулах чадвартай, төвлөрсөн нэгжтэй эсэхийг харуулдаг. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний бодлогын шалгуур үзүүлэлтүүд нь тус улсад эрүүл мэндийн ажиллах хүчний төлөвлөлт хийх үйл явц байгаа эсэх, боловсролын төлөвлөгөө нь эрүүл мэндийн үндэсний төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэх, эрүүл мэндийн ажилтнуудын хэрэгцээг үнэлэх институцийн загварууд байгаа эсэх талаар мэдээлэл өгдөг. Энэхүү модуль нь бусад модулиудад шалгуур үзүүлэлтүүдийн дагуу цуглуулсан мэдээллийг улс оронд үр дүнтэй ашиглах, ашиглах механизм байгаа эсэхийг харуулах гол түлхүүр юм.

### **3.2.11. Модуль 10. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний мэдээллийн систем**

Энэхүү модуль нь Эрүүл мэндийн мэдээллийн систем дэх хүний нөөцийн байдал (ЭММСХН), мэдээллийн менежмент, түүнийг ЭМСХНОУС 2020-ийн дагуу хэрэгжүүлж буй талаарх үзүүлэлтүүдийг тодорхойлно. Шалгуур үзүүлэлтүүд нь үндэсний ЭММСХН талаарх мэдээлэл нь эрүүл мэндийн ажилтнуудын талаарх олон улсын тайлангийн шаардлагыг хангахад бэлэн байгаа эсэхийг тодорхойлдог. Бусад үзүүлэлтүүд нь ЭММСХН нь боловсрол, сургалтын байгууллагуудын орц гарц, хөдөлмөрийн зах зээлд хамрагдах хүмүүс, хөдөлмөрийн зах зээл дээрх идэвхтэй хувьцааны тоо, хөдөлмөрийн зах зээлээс гарах тоо, эрүүл мэндийн байгууллага байгууламжийн байршил зэргийг хянах боломжтой эсэхийг харуулдаг.

#### **Дөрөв. ЭМСАХҮТ-ны хэрэгжилт**

ЭМСАХҮТ нь эрүүл мэндийн ажиллах хүчний бодлогын тулгамдсан асуудал, эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээл, түүний хамрах хүрээтэй холбоотой үзүүлэлтүүдийг агуулдаг. ЭМСАХҮТ-ны хэрэгжилт нь үндэсний хэмжээнд суурилсан, эрүүл мэндийн ажиллах хүчний талаар үнэлгээ хийх, дата цуглуулах ажлыг зохион байгуулах, улс орны хэмжээнд явагддаг үйл ажиллагаа юм.

ДЭМБ нь улс орнуудыг ЭМСАХҮТ-г хэрэгжүүлэхэд туслах зорилгоор багц арга хэмжээг боловсруулан гаргасан. Үүнд, гарын авлагаас гадна хэрэгжүүлэх заавар, мэдээллийн тайлан гаргах, дүрслэх, олон улсын харьцуулалт хийх вэб платформ орно.

ДЭМБ-ын бүс нутгийн байгууллагууд ЭМСАХҮТ-г хэрэгжүүлэхэд шууд тусалцаа үзүүлж, өөрийн бүс нутгийн улс орнуудын асуулгад хариу өгөх боломжтой.

#### **Тав. ЭМСАХҮТ-н хэрэглэх боломж, давуу тал**

Мета өгөгдлийн хуудсан дээр дурдсанчлан, ЭМСАХҮТ нь эрүүл мэндийн ажиллах хүчтэй холбоотой зохицуулалт болон бусад механизмын талаархи мэдээллийг өгдөг тоон ба 'чанарын' үзүүлэлтүүдийг агуулдаг. Засаглал болон эрүүл мэндийн ажиллах хүчний бодлогын талаарх 9-р модульд тусгагдсан институцийн үйл явц, төлөвлөгөө, нэгжийн хүртээмж нь тус тусдаа бодлогын холбогдох чиглэлд шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэх, ашиглах боломжийг бүрдүүлсэн. Нэмж дурдахад, холбогдох бодлогын талаарх тайланг ялангуяа модуль 10: Эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийн систем бүлэгт тусгагдсан мэдээллээр хангах боломжтой.

**Зургаа. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний үндэсний тооцоо, түлхүүр 78 үзүүлэлтийг гаргахад шаардлагатай мэдээллийн бэлэн байдлыг үнэлсэн нь**

**Зургаа. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тооцоо, түлхүүр 78 үзүүлэлтийг гаргахад шаардлагатай мэдээллийн бэлэн байдлыг үнэлсэн нь**

Шалгуур үзүүлэлт	№	Дэд үзүүлэлт	Мэдээллийн бэлэн байдал (1-гарна, 2-гаргахгүй)	Захиргааны статистик мэдээлэл (1-гарна, 2-гаргахгүй)	Хариуцах байгууллага	
					Үзүүлэлтийг хариуцан гаргах	Үзүүлэлтийг бодлогын түвшинд хариуцах
<b>Модуль 1 Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний хүний нөөц</b>	<b>1.1</b>	Эрүүл мэндийн ажилтны нягтрал (10.000 хүн ам дахь эрүүл мэндийн ажилтны тоо)	1	Эрүүл мэндийн үзүүлэлт (Эрүүл мэндийн салбарын хүний нөөц) -Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид	Эрүүл Мэндийн Хөгжлийн төв /ЭМХТ/, Эрүүл мэндийн байгууллагууд	Үндэсний Статистикийн Хороо /ҮСХ/, ЭМЯ /Эрүүл мэндийн Яам/
	<b>1.2</b>	Эрүүл мэндийн ажилтны нягтрал үндэсний дэд түвшинд (засаг захиргааны нэгжээс гаргасан 10.000 хүн ам дахь идэвхтэй ажиллах эрүүл мэндийн ажилтны тоо)	1		ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	ҮСХ, ЭМЯ
	<b>1.3</b>	Эрүүл мэндийн ажилтны тархалт, насны бүлгээр (тухайн мэргэжлийн дагуу, насны бүлгээр ангилсан идэвхтэй эрүүл мэндийн ажилтнуудын эзлэх хувь)	1		ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМЯ
	<b>1.4</b>	Эмэгтэй ажилтны эзлэх хувь (эрүүл мэндийн идэвхтэй ажиллах хүчний доторх эмэгтэй	1		ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМЯ

	эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь)				
<b>1.5</b>	Эрүүл мэндийн ажилтны тархалт-өмчлөлийн хэлбэрээр (өмчлөлийн хэлбэрээр идэвхтэй ажилтнуудын эзлэх хувь)	1	ЭМХТ Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын тоо, тусламж үйлчилгээний шатлалаар /үүдэн хувийн эмнэлэг/	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМЯ
<b>1.6</b>	Эрүүл мэндийн ажилтны тархалт эрүүл мэндийн- байгууллагын төрөл, үйл ажиллагааны чиглэлээр (байгууллагын төрлөөр идэвхтэй ажилтны эзлэх хувь)	1	Эрүүл мэндийн үзүүлэлт- эрүүл мэндийн салбарын хүний нөөц /ЭМХТ Эрүүл мэндийн статистик мэдээлэл "Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын тоо, тусламж үйлчилгээний шатлалаар, аймаг хотоор "	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМЯ
<b>1.7</b>	Гадаад эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь	1	Судалгаа	ЭМХТ, МИЛА	ЭМЯ
<b>1.8</b>	Гадаадад сургагдсан эрүүл мэндийн ажилтны хувь	2	Судалгаа	ЭМХТ, ХНБЗА	ЭМЯ
<b>1.9</b>	Эрүүл мэнд болон нийгмийн салбар дахь ажилтнуудын хүртээмжтэй байдал (Эрүүл мэнд болон нийгмийн салбарт ажиллаж буй ажилтнуудын тоог	1	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын тоо, нийгмийн салбар дахь ажилтнуудын тоо	ЭМХТ	ҮСХ, ЭМЯ, ХНХЯ

		бусад салбарын ажилтнуудын тоонд харьцуулсан харьцаа)				
<b>Модуль 2 Боловсрол болон сургалтын үйл ажиллагаа</b>	2.1	Эрүүл мэндийн салбар дахь боловсрол олгох, сургалт эрхлэх байгууллагуудын магадлан итгэмжлэлийн жагсаалт	1	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл-магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын жагсаалт. Төгсөлтийн дараах сургалтыг ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл- сургалт эрхлэх байгууллагын жагсаалт	БСШУЯ, ЭМЯ	БСШУЯ, ЭМЯ, ҮСХ
	2.2	Боловсролын болон сургалтын үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа	2	Холбогдох хууль, журам	ЭМХТ, АШҮИС	БСШУЯ, ЭМЯ, ҮСХ
	2.3	Боловсрол болон сургалтад хамрагдах өргөдөл (эрүүл мэндийн ажилтнуудын боловсрол, сургалтын өргөдөл ба сургалт эрхлэх байгууллагын харьцаа)	2	Хүсэлт гаргасан иргэн, эрүүл мэндийн ажилтны тоо, сургалтын байгууллагын тоо	БСШУЯ Мэдээлэл статистикийн газар, ЭМХТ, ЭМЯ	ҮСХ
	2.4	Сургалт эрхлэх байгууллагууд дахь элсэлтийн харьцаа (эрүүл мэндийн ажилтнуудын боловсрол, сургалтын элсэлт ба сургалт	1	Элсэгчдийн тоо, сургалт эрхлэх байгууллагын тоо	БСШУЯ - Мэдээлэл статистикийн газар, ЭМХТ, ЭМЯ	БСШУЯ, ЭМЯ, ҮСХ

		эрхлэх байгууллагын харьцаа)				
	2.5	Боловсрол олгох, сургалт эрхлэх байгууллага дахь мэргэшсэн багш болон оюутнуудын харьцаа (тухайн жилийн сургалтын программд суралцаж буй оюутан ба багшийн харьцаа)	1	Дээд боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик, сургалт эрхлэх байгууллагын сургагч багш, суралцагчийн тоо	БСШУЯ - Мэдээлэл статистикийн газар, ЭМХТ, ЭМЯ, ЭМБ	ҮСХ
	2.6	Боловсрол олгох, сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаанаас гарсан/ хаясан хүмүүсийн харьцаа	2	Судалгаа	БСШУЯ - Мэдээлэл статистикийн газар, ЭМХТ, ЭМЯ, ЭМБ	ҮСХ
	2.7	Боловсрол олгох, сургалт эрхлэх байгууллага ба оюутнуудын төгсөлтийн харьцаа	1	Тухайн программыг төгсч буй оюутнуудыг анх элссэн оюутны тоонд харьцуулсан харьцаа	БСШУЯ Мэдээлэл статистикийн газар, ЭМЯ	ҮСХ
<b>Модуль 3 Боловсрол ба сургалтын журам, магадлан итгэмжлэл</b>	3.1	Боловсрол ба сургалтын хугацаа, агуулгын стандарт (Эрүүл мэндийн ажилтнуудын боловсрол, сургалтын хугацаа, агуулгын талаарх стандарт)	2	Хөтөлбөрт тавигдах шаардлага байдаг боловч агуулгын стандарт байдаггүй	БСШУЯ ЭМЯ	БСШУЯ ЭМЯ
	3.2	Боловсрол олгох, сургалт эрхлэх байгууллагын магадлан	1	1. Их дээд сургуулийг БСШУЯ харьяа Боловсролын Магадлан итгэмжлэл, үндэсний	БСШУЯ ЭМЯ	БСШУЯ ЭМЯ

		итгэмжлэх механизм, тэдгээрийн хөтөлбөр		зөвлөл магадлан итгэмжилдэг		
				2.Эмнэлгийн магадлан итгэмжлэл- ЭМХТ-ийн МИЛА магадлан итгэмжилдэг боловч, төрөлжсөн мэргэжил, дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл олгогддоггүй		
				3. Богино хугацааны багц цагийн сургалт эрхлэн явуулдаг байгууллагуудыг магадлан итгэмжлэх механизм байхгүй		
	3.3	Нийгмийн хариуцлагын стандарт (магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд нийгмийн хариуцлагын стандарт багтдаг эсэх)	2	Нийгмийн хариуцлагын стандарт бий болгох	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл	БСШУЯ, ЭМЯ
	3.4	Нийгмийн хариуцлагын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлдэг эсэх	2	Нийгмийн хариуцлагын стандарт бий болгох	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл	БСШУЯ, ЭМЯ
	3.5	Эрүүл мэндийн нийгмийн үзүүлэлтийн стандартууд (магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн нийгмийн	2	тусгагдаагүй	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл	БСШУЯ, ЭМЯ

	үзүүлэлтийн стандарт байдаг эсэх)				
3.6	Мэргэжил хоорондын боловсролын стандарт (магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд нийгмийн үзүүлэлтийн стандарт байдаг эсэх)	2	Мэргэжил хоорондын боловсролын стандарт бий болгох	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл	БСШУЯ, ЭМЯ
3.7	Магадлан итгэмжлэлийн стандартын гэрээ (Эрүүл мэндийн ажилтныг сургах сургалт эрхлэх байгууллагууд болон зохицуулагч байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хийсэн магадлан итгэмжлэлийн стандартын гэрээ)	2	Боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс их дээд сургуулиудад гэрчилгээ олгодог. Төгсөлтийн дараах сургалтын хувьд- ЭМЯ дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс гаргасан эрхийн хугацаанд сургалт эрхлэх байгууллага нь ЭМХТ-тэй гэрээ байгуулдаг.	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл, ЭМХТ	БСШУЯ, ЭМЯ
3.8	Тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалт (улсын хэмжээнд тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалтын систем)	1	Улсын хэмжээнд тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалтыг ЭМХТ-өөс сургалт эрхлэх байгууллагуудад эрх олгон явагддаг.	ЭМХТ	БСШУЯ, ЭМЯ
3.9	Эмнэл зүйн дадлага сургалт (Үндэсний буюу улсын хэмжээний боловсролын хөтөлбөрт эмнэл зүйн дадлага сургалт тусгагдсан байдал- Эрүүл	1	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан боловсролын хөтөлбөртэй	Боловсролын Магадлан Итгэмжлэх Зөвлөл	БСШУЯ, ЭМЯ



		мэндийн ажилтнуудад зориулсан)				
<b>Модуль 4 Сургалтын санхүүжилт</b>	4.1	Дээд боловсролын нийт зардал	2	Төрийн болон хувийн хэвшлийн дээд боловсролын байгууллагуудын нийт зардлыг тооцдог болох	Боловсролын үнэлгээний төв	СЯ, ЭМЯ, БСШУЯ, БХЯ, ҮСХ
	4.2	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын боловсролын нийт зардал (тасралтгүй сургалт орохгүйгээр)	2	Судалгаа	ЭМХТ, Боловсролын үнэлгээний төв	СЯ, ЭМЯ, БСШУЯ, БХЯ, ҮСХ
	4.3	Нэг оюутанд ноогдох сургалтын дундаж төлбөр (нэг оюутны сургалтын зардал элссэнээс хойш жил тус бүрээр)	1	Боловсрол, Шинжлэх ухаан статистик үзүүлэлт дэх -төрийн өмчийн сургуулийн бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээг тооцоолон гаргадаг боловч Анагаахын салбарын тусад нь тооцдоггүй	БСШУЯ, СЯ, ЭМЯ	ҮСХ
	4.4	Хувьсах боловсрол, сургалтад хөрөнгө оруулалт хийдэг эсэх	2	Хувьсах боловсролд хөрөнгө оруулахад шаардлагатай төсвийн нөөц, Эрүүл мэндийн ажиллах хүчний үндэсний стратеги, улсын төсөвт тусгагдсан эсэхийг үнэлэн гаргана	ЭМХТ, Боловсролын үнэлгээний төв	СЯ, ЭМЯ, БСШУЯ, БХЯ, ҮСХ

	4.5	Эрүүл мэндийн ажилтнуудын боловсрол олгох, сургалтад хамрагдсан 1 төгсөгчид зарцуулах нийт зардал /төрийн болон хувийн байгууллагаас гаргасан/	2	Эрүүл мэндийн үзүүлэлт "Эрүүл мэндийн салбарын хүний нөөц" 2018 онд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 464, гадаад сургалтад 169, зайн сургалтад 1231, багц цагийн сургалтад 2709 нийт 4594 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр суралцаж төгссөн байна- тайлан гардаг боловч 1 төгсөгчид зарцуулах нийт зардлыг тооцдоггүй	ЭМХТ, Боловсролын үнэлгээний төв	СЯ, ЭМЯ, БСШУЯ, БХЯ, ҮСХ
	4.6	Эмнэлгийн тусгай мэргэшил эзэмшсэн боловсролын хөтөлбөрийг дуусгасан төгсөгчийн зардал (мэргэжил, байгууллагаар нь төгсөгч тус бүрийн одоогийн зардал)	2	Судалгаа	ЭМХТ АШУУИС	СЯ, ЭМЯ, БСШУЯ,
	4.7	Мэргэшсэн сургагч багшийн зардал	2	Судалгаа	ЭМХТ АШУУИС	СЯ, ЭМЯ, БСШУЯ,
	4.8	Тасралтгүй сургалт, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад зарцуулсан нийт зардал	2	Судалгаа	ЭМХТ Боловсролын үнэлгээний төв	СЯ, ЭМЯ, БСШУЯ, БХЯ, ҮСХ

<b>Модуль 5 Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлийн урсгал</b>	5.1	Төгсөгчид нэг жилийн дотор дадлага хийж эхлэх	2	Судалгаа	ЭМХТ АШУУИС анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй их дээд сургуулиуд	ЭМЯ ХНХЯ
	5.2	Хүний нөөцийн хэрэгцээг дотоод нөөцөөс нөхөх (сургалтад хамрагдсан дотоодын эрүүл мэндийн идэвхтэй шинэ ажилтнуудыг нийт хөдөлмөрийн зах зээл дэх идэвхтэй эрүүл мэндийн ажилтанд харьцуулсан харьцаа)	2	Судалгаа	ЭМХТ	ЭМЯ ХНХЯ
	5.3	Гадаад эрүүл мэндийн ажилтнуудын тоо	1	Гадаад эрүүл мэндийн идэвхтэй шинэ ажилтнуудыг нийт хөдөлмөрийн зах зээл дэх идэвхтэй эрүүл мэндийн ажилтанд харьцуулсан хувь	ЭМХТ	ЭМЯ
	5.4	Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлээс өөрийн хүсэлтээр гарах хувь хэмжээ	2	Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээл дэхь идэвхтэй эрүүл мэндийн ажилтнуудаас сайн дураар гарч буй тоог нийт хөдөлмөрийн зах зээл дэх идэвхтэй эрүүл мэндийн	ЭМЯ	ЭМЯ ХНХЯ

				ажилтанд харьцуулсан харьцаа		
	5.5	Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлээс албадан гарах түвшин	2	Эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээл дэхь идэвхтэй эрүүл мэндийн ажилтнууд ажлаас халагдаж буй тоог нийт хөдөлмөрийн зах зээл дэх идэвхтэй эрүүл мэндийн ажилтанд харьцуулсан харьцаа /мэргэжил, хүйсээр/	ЭМЯ	ЭМЯ ХНХЯ
	5.6	Ажилгүйдлийн түвшин	2	Судалгаа	ХНХЯ ЭМЯ	ҮСХ
	5.7	Ажлын байрны түвшин	1	Сул ажлын байрны тоог нийт ажлын байрны тоонд харьцуулсан харьцаа	ЭМХТ	ЭМЯ
<b>Модуль 6 Хөдөлмөр эрхлэлтийн байдал болон хөдөлмөрийн нөхцөл</b>	6.1	7 хоногийн ажлын цагийн тоо	1	Хөдөлмөрийн тухай хууль	ХНХЯ ЭМЯ	ХНХЯ ЭМЯ
	6.2	Хагас цагаар гэрээний дагуу ажилладаг ажилтнуудын эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдад эзлэх хувь	2	Судалгаа	ХНХЯ ЭМЯ	ХНХЯ ЭМЯ
	6.3	Ажлын цаг, нөхцөлийг зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт	1	Хөдөлмөрийн тухай хууль	ХНХЯ ЭМЯ	ХНХЯ ЭМЯ

6.4	Салбарын хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулсан дүрэм, журам	1	Хөдөлмөрийн тухай хууль болон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээгээр зохицуулагдана	ХНХЯ ЭМЯ	ХНХЯ ЭМЯ
6.5	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын нийгмийн хамгааллын чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалт	1	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолын хавсралт	ЭМЯ	ЭМЯ
6.6	Хувиараа хөдөлмөр эрхэлж буй эрүүл мэндийн ажилтнуудын салбарын нийт ажиллагчдад эзлэх хувь	2	Судалгаа	ЭМЯ	ЭМЯ
6.7	Давхар хөдөлмөр эрхлэлтийн талаар хууль эрх зүйн зохицуулалт	2	Судалгаа	ЭМЯ	ЭМЯ
6.8	Эрүүл мэндийн ажилтны зайлшгүй үзүүлэх үйлчилгээний талаар хууль эрх зүйн зохицуулалт	1	Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль	ЭМЯ ХЗДХЯ	ЭМЯ ХЗДХЯ
6.9	Эрүүл мэндийн ажилтнуудыг гадны халдлагаас сэргийлэх талаар хууль эрх зүйн зохицуулалт	2	Зөрчлийн тухай хуулийн 5.2, 5.3, 6.21-рт заагдсан боловч эрүүл мэндийн ажилтанг тусгайлан заагаагүй	ЭМЯ ХЗДХЯ	ЭМЯ ХЗДХЯ

	6.10.	Сүүлийн 12 сарын хугацаанд эрүүл мэндийн ажиллагчид, үйлчлүүлэгч, эрүүл мэндийн байгууллагын эсрэг гарсан халдлагын тоо	1	Судалгаа	ЦЕГ, ЭМЯ	ХНХЯ ЭМЯ
<b>Модуль 7 Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний зардал, цалин хөлс</b>	7.1	Эрүүл мэндийн ажилтнуудын нийт зардал	2	Эрүүл мэндийн салбар дахь төрийн байгууллагын ажиллах хүчний зардлыг тооцоолон гаргадаг боловч хувийн хэвшлийнхнийг гаргахад хүндрэлтэй /тоо баримтаас/	Татварын Ерөнхий Газар, СЯ, ЭМХТ	ҮСХ
	7.2	Эрүүл мэндийн ажилтныг хөгжүүлэх сургалт, тэтгэлэг болон нийгмийн хамгааллын нийт зардал	2	Судалгаа	ЭМЯ СЯ	ҮСХ
	7.3	Эрүүл мэндийн ажилтнуудад олгосон нөхөн олговрын нийт зардал	2	Судалгаа	НДЕГ, ЭМДЕГ, ЭМЯ, ТЕГ, ХНХЯ	ЭМЯ
	7.4	Эрүүл мэндийн ажилтнуудад төсвөөс олгосон нөхөн олговрын нийт зардал	2	Судалгаа	НДЕГ, ЭМДЕГ, ЭМХТ, ТЕГ, ХНХЯ	ЭМЯ
	7.5	Шинээр ажилд орогсдын дундаж цалин хөлсний хэмжээ/нэмэгдлүүд орохгүйгээр/	1	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээгээр зохицуулагдана	НДЕГ, ТЕГ, ХНХЯ	ЭМЯ

	7.6	Төрийн байгууллагын ажилтнуудын цалингийн дээд хязгаарыг тогтоосон хууль эрх зүйн зохицуулалт байдаг эсэх	1	Хөдөлмөрийн тухай хууль, мөн төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээгээр зохицуулагдана	НДЕГ, ТЕГ, ХНХЯ	ЭМЯ
	7.7	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж цалингийн зөрүүний хэмжээ	2	Судалгаа	НДЕГ, ЭМДЕГ, ЭМХТ, ТЕГ, ХНХЯ	ЭМЯ
<b>Модуль 8 Эрүүл мэндийн ажилтны ур чадвар</b>	8.1	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын дунд эмнэлэгт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудын эзлэх хувь	1	ЭМХТ Эрүүл мэндийн үзүүлэлт эрүүл мэндийн салбарын хүний нөөц	ЭМХТ	ЭМЯ, ҮСХ
	8.2	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын дунд урт хугацаанд тусламж үзүүлдэг асаргааны байгууллагад ажилдаг ажилтнуудын эзлэх хувь	2	Судалгаа	ЭМХТ	ЭМЯ, ҮСХ
	8.3	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын дунд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын эзлэх хувь	1	ЭМХТ Эрүүл мэндийн үзүүлэлт эрүүл мэндийн салбарын хүний нөөц	ЭМХТ	ЭМЯ, ҮСХ
	8.4	100 000 хүн амд ногдох мэс заслын мэргэжилтний тоо	1	ЭМХТ Эрүүл мэндийн үзүүлэлт эрүүл мэндийн салбарын хүний нөөц	ЭМХТ	ЭМЯ, ҮСХ
	8.5	100 000 хүн амд ногдох өрхийн эрүүл мэндийн ажилтны тоо	1	ЭМХТ Эрүүл мэндийн үзүүлэлт эрүүл мэндийн салбарын хүний нөөц	ЭМХТ, НЭМГ	ЭМЯ, ҮСХ

	8.6	Нарийн мэргэжлийн сувилахуйн тусламж үйлчилгээ	1	ЭМХТ- Эрүүл мэндийн статистик үзүүлэлт	ЭМХТ, НЭМГ	ЭМЯ
	8.7	Олон улсын хэмжээнд баримтлах эрүүл мэндийн бодлого, журмыг хэрэгжүүлэх ур чадвар бүхий хүний нөөц	2	Тусгагдаагүй	НЭМҮТ	ЭМЯ НЭМҮТ
	8.8	Талбар дахь тархвар зүйн сургалтын хөтөлбөр	1	Талбар дахь тархвар зүйн сургалтын хөтөлбөртэй	НЭМҮТ АШУҮИС ЭМХТ	ЭМЯ
<b>Модуль 9 Засаглал ба эрүүл мэндийн ажиллах хүчний бодлого</b>	9.1	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын салбар хоорондын уялдаа холбоо, хуваарилалтыг зохицуулах механизм	2	Эрүүл мэндийн салбар хоорондын ажиллах хүчний асуудлыг зохицуулах бие даасан институцийн механизм байдаггүй. Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай	төрийн болон төрийн бус байгуулагууд, олон улсын байгууллага, яамд	ЭМЯ
	9.2	Эрүүл мэндийн салбарын ажилтны төв нэгж	1	Эрүүл мэндийн ажилтнуудын талаар баримтлах бодлого, төлөвлөгөө боловсруулж, хяналт тавих үүрэгтэй Эрүүл мэндийн яамны дэргэдэх эрүүл мэндийн ажилчдын бүрэлдэхүүн	ЭМХТ	ЭМЯ
	9.3	Эрүүл мэндийн салбарын ажилтныг төлөвлөх үйл явц (Эрүүл мэндийн ажилтнуудыг төлөвлөх	2	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг төлөвлөх механизм, загвартай болох	БСШУЯ, ЭМЯ	БСШУЯ, ЭМЯ



		механизм, загвар байгаа эсэх)				
	9.4	Эрүүл мэндийн талаарх үндэсний бодлого, төлөвлөгөө болон боловсролын бодлого, төлөвлөгөөний уялдаа	2	Эрүүл мэндийн ажилтнуудын боловсролын төлөвлөгөө, эрүүл мэндийн үндэсний төлөвлөгөө, эрүүл мэндийн ажиллах хүчний үндэсний стратегитай болох	БСШУЯ, ЭМЯ	БСШУЯ, ЭМЯ
	9.5	Эрүүл мэндийн ажилтнуудын хэрэгцээг үнэлэх институцийн загвар	2	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай боловсон хүчнийг үнэлэх, хянах институцийн загвартай болох	ЭМХТ	ЭМЯ
<b>Модуль 10 Эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем</b>	10.1	Олон улсад тайлагнах чадамжтай эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Хүний нөөцийн мэдээллийн систем хийгдэж байгаа	ЭМХТ	ЭМЯ
	10.2	ДЭМБ-ын олон улсад ажиллах дүрмийн тайланг мэдээлэх чадамжтай эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Эрүүл мэндийн ажилтнуудыг олон улсад ажиллуулах ДЭМБ-аас гаргасан дүрмийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг нэгтгэн өгөх чадамж одоогоор үгүйлэгдэж байна	ЭМХТ, ДЭМБ	ЭМЯ, ДЭМБ, ҮСХ

10.3	Төрөлт удирдах эрүүл мэндийн хүний нөөцийн ур чадварын талаарх тайлан гаргах чадамжтай эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Төрөлт удирдах ур чадвартай мэргэжилтнүүдийн мэдээ мэдээллийг нэгтгэх мэдээллийн системгүй	ЭМХТ, ЭХЭМҮТ	ЭМЯ
10.4	Боловсрол болон сургалт эрхлэх байгууллагуудын үр дүнг мэдээлэх чадамжтай эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Судалгаа	ЭМЯ	ҮСХ
10.5	Хөдөлмөрийн зах зээлд орох ажиллах хүчний тоог хянах эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Хүний нөөцийн мэдээллийн систем хийгдэж байгаа	ЭМХТ	ЭМЯ
10.6	Хөдөлмөрийн зах зээл дэхь идэвхтэй ажиллах хүчний тоог хянах ЭМСХНМС	2	Хүний нөөцийн мэдээллийн систем хийгдэж байгаа	ЭМХТ	ЭМЯ
10.7	Хөдөлмөрийн зах зээлээс гарах ажиллах хүчний тоог хянах эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем	2	Хүний нөөцийн мэдээллийн систем хийгдэж байгаа	ЭМХТ	ЭМЯ
10.8	Эрүүл мэндийн байгууллагуудын геодезын байршлыг тогтоох эрүүл мэндийн	2	Эрүүл мэндийн байгууллагуудын геодезын байршилтай болох	ЭМХТ НЭМГ НЭМҮТ	ЭМЯ

		салбар дахь хүний нөөцийн мэдээллийн систем				
--	--	---	--	--	--	--

## Долоо. Дүгнэлт

ДЭМБ-ээс гаргасан ЭМСАХ-ний гарын авлага нь арван модулиудаас бүрдсэн 78 үндсэн шалгуур үзүүлэлтийг агуулсан байдаг бөгөөд эдгээр нь тухайн орны эрүүл мэндийн ажилтнуудын байдал, чиг хандлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилготой юм.

Эдгээр үзүүлэлтүүд нь эрүүл мэндийн ажилтнуудын тэргүүлэх чиглэлийг хамарсан бөгөөд улс орон, бүс нутгийн болон дэлхийн тайланд хамааралтай мэдээлэл болдог байна.

Бид ДЭМБ-ээс гаргасан ЭМСАХ-ний гарын авлагаас үндсэн шалгуур үзүүлэлт тус бүрийг тооцоход шаардлагатай мэдээллийг Монгол улсад хэрэгжиж буй холбогдох хууль эрх зүй, бодлогын баримт бичиг, хэрэглэгдэх дата мэдээлэл зэргийг тулгаж үзэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Иргэний бүртгэл мэдээллийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, АШУҮИС, ҮСХ, БСШУЯ болон бусад сургалт эрхлэгч байгууллагууд болон эрүүл мэндийн байгууллагуудаас гаргах боломжтой гэж үзсэн. Шууд хэрэглэх бэлэн статистик тоо баримт гарахгүй тохиолдолд судалгаа хийж, судалгаанд үндэслэн тооцоолон гаргах боломжтой гэж үзсэн. Нийт 10 бүлэг 78 үзүүлэлтээс гаргах боломжтой гэж үнэлсэн 33, одоогийн нөхцөл байдалд тооцоолон гаргах боломжгүй гэж үнэлсэн 45 үзүүлэлт байна.

ЭМСАХТ-ний шалгуур үзүүлэлтийг багтаасан 10 модуль нь эрүүл мэндийн салбарын бүрэлдэхүүн хэсэг, бодлогын хүрээг бүхэлд нь хамарсан хэдий ч тухайн улсын эрүүл мэндийн тогтолцооны онцлог, дээд болон төгсөлтийн дараах сургалтын орчин, эрүүл мэндийн мэдээллийн системийн хөгжүүлэлт зэргээс шалтгаалан шалгуур үзүүлэлтийг нэмж, хасах, өөрчлөх боломжтой гэж ДЭМБ-ээс үзсэний дагуу өөрийн орны онцлогт тааруулж гаргах боломжтой гэж дүгнэсэн.

Хэрэв бид өөрийн орны онцлогт тохируулан дээрх үзүүлэлтээс тооцоолон гаргаж хэрэгжүүлж эхэлвэл эрүүл мэндийн ажиллах хүчний боловсрол, сургалт, ажлын байранд байршуулах, ажиллуулах, тогтоон барих зэрэг олон талт асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэх цаашлаад хэрэгцээ, шаардлагын талаархи ойлголтыг бий болгож чадна гэж үзэж байна. Тодруулбал, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний чадавхи, динамикийг хянахын тулд бүртгэл нь чухал бөгөөд ингэснээр улс орнуудын хоорондох эрүүл мэндийн ажилтнуудын тоо баримт, үзүүлэлт, бүртгэл, мэдээллийг солилцох боломж бүрдэнэ гэж үзсэн.

Эцэст нь хэлэхэд, ЭМСАХТ нь улс орнуудын одоогийн эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тулгамдсан асуудлууд, төлөвлөлтийн системийг оновчтой болгох зэрэг томоохон бодлогын асуудлуудыг шийдвэрлэх, эргэн харах сэдэл болж чадна. Жишээлбэл:

- Одоогийн эрүүл мэндийн салбарын ажилтнууд чанартай, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, зохих чадвартай байж чадаж байна уу?
- Байгаа нөөцийг илүү сайн хуваарилах, бүтээмжийг нэмэгдүүлэх, үр ашигтай бодлого баримтлах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг үр дүнтэй ажиллуулж гүйцэтгэлийг сайжруулах замаар өнөөгийн цоорхойг хэрхэн арилгах вэ?
- Боловсрол, үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх замаар өнөөгийн цоорхойг хэрхэн арилгах вэ?

- Гүйцэтгэлийг сайжруулах, орцыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, стратегийг хэрхэн санхүүжүүлэх вэ? (хөрөнгө оруулалт, давтагдах зардал (цалин) зэрэг бодлого, стратегийн хувилбаруудыг засгийн газар (санхүү, боловсрол, хөдөлмөрийн яам) -тай хийсэн хэлэлцээр, хувийн хэвшилтэй хийсэн хэлэлцээр ярьж тохиролцох)
- Эрүүл мэндийн ажилласадын бүтээмж нь ажлаасаа гарсан эрүүл мэндийн ажилтнуудын алдагдлыг нөхөж чаддаг уу? Эрүүл мэндийн ажилчдад зориулсан санхүүгийн урамшуулал нь тэднийг ажиллах хүч дутмаг газар нутагт суурьшихад түлхэц өгч, орон нутаг, бүс нутагт эрүүл мэндийн ажиллах хүчний тэнцвэртэй хуваарилалтад хүргэж чадаж байна уу? зэрэг асуултад хариулж чадах сэдэл болно гэж үзлээ.